

ТУСГАЙ НӨХЦӨЛИЙН ГЭРЭЭ

/Зээлийн хөнгөлөлттэй нөхцөл/

2022 оны 09 сарын 08-ны өдөр

Дугаар № 5131202209080002

100/2022

ЭНЭХҮҮ ГЭРЭЭ-г

- Нэг талаас “ХААН Банк” ХХК буюу түүнийг төлөөлж ХУД 15-р хороо, Оргил шилтгээний 2 давхар хаягт орших Оргил тооцооны төв салбар/тооцооны төвийн захирал Г.Дамбасүрэн /цаашид “Банк” гэх/;

-Нөгөө талаас 8 хаягт орших АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ, /РД: 6021646/ түүнийг төлөөлж Захирал албан тушаалтай, регистрийн УЮ64031318 дугаартай, Монгол Улсын иргэн ШАГДАРСҮРЭН овогтой БАЯНМӨНХ /цаашид “Байгууллага” гэх хамтад нь “Талууд” гэх) нар нь Монгол улсын Иргэний хууль, Банкны тухай хууль, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, журмыг үндэслэн талууд хүсэл зоригоо чөлөөтэй илэрхийлж, энэхүү гэрээнд заасан нөхцөлийг харилцан зөвшөөрснөөр байгуулсан болно

НЭГ. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- 1.1. Энэ гэрээний зорилго нь байгууллага өөрийн ажилтнуудад цалин түүнтэй адилтгах орлогыг Цалин дамжуулах үйлчилгээ /цаашид “Үйлчилгээ” гэх/-ээр дамжуулан ажилтнуудын нэрийн дансанд шилжүүлэн олгоход Банктай хамтран ажиллах, банкны шаардлага хангасан хамтран ажиллах гэрээт байгууллагын ажилтнуудад нийтэд санал болгосноос хөнгөлөлттэй нөхцөлөөр зээл олгох, байгууллага зээл буцаан төлөгдөх үйл ажиллагаанд банктай хамтран ажиллахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Гэрээний хугацаа: 12 сар. Гэрээний хугацаа дуусгавар болохоос 1 сарын өмнө талууд гэрээг дуусгавар болох талаар харилцан тохиролцоогүй бол 12 сарын хугацаагаар 1 удаа сунгагдсан тооцно. Гэрээний хугацаа дуусгавар болсон нь энэхүү гэрээний дагуу олгогдсон зээл буцаан төлөгдөхөд байгууллагын хүлээсэн үүргээс чөлөөлөх үндэслэл болохгүй.
- 1.3. Энэ гэрээнд тусгагдсан нэр томъёог дараах утгаар ойлгоно. Үүнд:
 - 1.3.1. **Цалин дамжуулах үйлчилгээ** гэж байгууллага нь ХААН Банкнаар дамжуулан өөрийн ажилтнууддаа цалин түүнтэй адилтгах орлого олгохыг,
 - 1.3.2. **Цахим суваг** гэж интернэт холболт бүхий төхөөрөмж ашиглан www.corporate.khanbank.com хаягаар байгууллага ажилтнууддаа өөрийн ХААН Банк дахь харилцах, хадгаламжийн данс болон Банкны түр дансыг ашиглан цалин түүнтэй адилтгах орлогыг дамжуулах цахим хуудсыг хэлнэ.
 - 1.3.3. **Харилцагч** гэж үйлчилгээ авч буй байгууллага болон түүний ажилтныг хэлнэ.
 - 1.3.4. **Өөрийн цахим хуудас** гэж Банкны www.khanbank.com хаягийг хэлнэ.
- 1.4. Цалин дамжуулах нөхцөл нь салбар нэгж эсхүл цахим суваг байна.
- 1.5. Байгууллагын ажилтнууд нь ХААН Банканд нэрийн данс нээлгэсэн, тухайн дансанд төлбөрийн карт авсан байна.
- 1.6. **Банкнаас олгох зээлийн нөхцөл:**
 - 1.6.1 Зээлдэгчид олгох зээлийн нөхцөл нь тухайн үед мөрдөгдөж буй банкны холбогдох журмаар зохицуулагдана. Тухайн үед мөрдөгдөж буй банкны холбогдох журмын шаардлагыг хангасан ажилтанд зээл олгох бөгөөд зээл олгох эсэх шийдвэрийг банк бие даан гаргана.
 - 1.6.2 Банк зээлийн шийдвэр гаргахдаа зээл хүсэгч ажилтны эрсдэлийн үнэлгээнээс хамааруулан зээлийн хүүгийн хэмжээг нэмэгдүүлэн шийдвэрлэж болно.
 - 1.6.3 Дараах тохиолдолд банк байгууллагын ажилтнуудад зээл олгохоос татгалзана;
 - 1.6.3.1 Байгууллага ажил үүргээ хууль, тогтоомжийн дагуу гүйцэтгээгүй, эсхүл эрх бүхий байгууллагын шийдвэрээр үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх боломжгүй болсон, ямар нэг ноцтой сөрөг нөлөө үзүүлэхүйц болон үзүүлж болохуйц нөхцөл байдал үүссэн гэж Банк үндэслэлтэйгээр үзсэн;
 - 1.6.3.2 Байгууллагын ажилтнуудад олгосон зээлийн багцын хугацаа хэтрэлт өндөр болсон гэж банк үзсэн тохиолдолд зээл олголтыг хугацаа хэтрэлт хэвийн болох хүртэл хугацаанд зогсоох;
- 1.7 Техникийн саатлын улмаас төлбөр тооцоо хойшлогдсон тохиолдолд банк хариуцлага хүлээхгүй.

ХОЁР. ЦАЛИН ДАМЖУУЛАХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НӨХЦӨЛ

- 2.1. Байгууллага нь гэрээний 2.6 эсхүл 2.7-д заасан нөхцлөөр Үйлчилгээг авч болно.
- 2.2. Байгууллага нь дансгүй тохиолдолд Банкны түр дансаар дамжуулан үйлчилгээг авна.
- 2.3. Үйлчилгээний хураамжийг гүйлгээ тутмаар тооцно.
- 2.4. Үйлчилгээний хураамж нь тухайн үед хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Банкны шимтгэл, хураамжийн ерөнхий нөхцөлийн дагуу байх ба өөрийн цахим хуудсаар мэдээлнэ.
- 2.5. Банк нь үйлчилгээний шимтгэл, хураамжийн ерөнхий нөхцөлд өөрчлөлт орох тухай өөрийн цахим хуудсаар мэдээллэснээс хойш хуанлийн 30 хоногийн дотор Байгууллага өөрчлөлтийн талаар санал, хүсэлт гаргаагүй бол уг өөрчлөлтийг хүлээн зөвшөөрсөнд тооцно.
- 2.6. **Салбар нэгжээр дамжуулах нөхцөл**
 - 2.6.1. Байгууллага өөрийн ажилтнуудын цалинг Банкны түр дансаар дамжуулан олгох бол цалингийн санхүүжилтийг цалин олгох өдрийн 14:00 цагаас өмнө 5131000017 тоот дансанд байршуулан, цалингийн цэс /цалингийн цэс бүхий Excel файл/-г khongorzul.k@khanbank.com хаягаар эсхүл цахим сувгаар дамжуулан Банкинд ирүүлнэ.
 - 2.6.2. Цахим сувгаар цалингийн цэс /цалингийн цэс бүхий Excel файл/-г ирүүлэхтэй холбоотой нөхцөлийг гэрээний 2.8-д заасны дагуу зохицуулна.
 - 2.6.3. Цахим сувгаар ирүүлсэн цалингийн цэс /цалингийн цэс бүхий Excel файл/-г Банкны ажилтан баталгаажуулснаар цалин дамжуулах гүйлгээ хийгдэнэ.
- 2.7. **Цахим сувгаар цалин дамжуулах нөхцөл**
 - 2.7.1. Энэхүү гэрээ хүчин төгөлдөр болсноор байгууллагын Банканд бүртгэлтэй и-мэйл хаягаар цалин дамжуулах үйлчилгээг ашиглах нэвтрэх нууц үг үүсгэх холбоосыг хүргүүлнэ.
 - 2.7.2. Байгууллага и-мэйлээр авсан холбоосоор хандан нэвтрэх нууц үг үүсгэх болон өөрчлөхдөө том, жижиг үсэг, тоо, тэмдэгт холилдсон 8-20 тэмдэгт оруулна.
 - 2.7.3. Байгууллага үйлчилгээний нэвтрэх болон гүйлгээний нууц үгийг заавал өөр хоорондоо ялгаатай байхаар үүсгэнэ.
 - 2.7.4. Цалин дамжуулахад ашиглах нэвтрэх болон гүйлгээ хийх нууц үгээ 2 сар тутамд солино.
 - 2.7.5. Байгууллага цалин дамжуулах үйлчилгээнд 60-аас дээш хоног холбогдоогүй бол үйлчилгээний эрх автоматаар “Зогсоосон” төлөвт шилжинэ.
 - 2.7.6. Нэвтрэх нууц үг сэргээхэд нууц үг идэвхжүүлэх кодын хүчинтэй хугацаа нь Банкны серверээс идэвхжүүлэх код үүсгэснээс хойш 15 минут байна.
 - 2.7.7. Үйлчилгээ нь байгууллага өөрийн дансаар гүйлгээ хийж буй тохиолдолд 24 цагийн турш хийгдэнэ, харин 3 сая төгрөгөөс дээш дүнтэй Банк хоорондын гүйлгээ хийх тохиолдолд тухайн өдрийн гүйлгээ нь ажлын өдрүүдэд 09:00-16:00 цагаар тасалбар болно. Заасан хугацаанаас хойш хийгдсэн гүйлгээ дараагийн ажлын өдөр хийгдсэнд тооцогдоно.
 - 2.7.8. Үйлчилгээний нэвтрэх нууц үг, гүйлгээний нууц үгийг дараалан 3 удаа буруу оруулсан тохиолдолд Банк үйлчилгээг түр зогсооно.

ГУРАВ. ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ

3.1 Банкны эрх

- 3.1.1 Ажилтанд зээл олгох эсэхийг бие даан шийдвэрлэх;
- 3.1.2 Цалин дамжуулах шимтгэл, хураамжийн хэмжээг дангаар тогтоох, өөрчлөх, гэрээнд заасан нөхцөлийн дагуу Байгууллагын данснаас үл маргах журмаар суутгах, дансан дахь үлдэгдэл нь шимтгэл, хураамжийг суутгахад хүрэлцэхгүй тохиолдолд үйлчилгээ үзүүлэхээс татгалзах эрхтэй.
- 3.1.3 Мөнгө угаах, угаах, терроризмийг санхүүжүүлэхтэй тэмцэх хуулийн дагуу байгууллагын болон гүйлгээний талаар мэдээллийг шаардах, байгууллага мэдээлэл өгөхөөс татгалзсан болон худал, дутуу мэдээлэл өгсөн тохиолдолд нэг талын санаачлагаар гэрээг цуцлах, цалингийн гүйлгээг дамжуулахгүй байх эсвэл цаашид үйлчилгээ үзүүлэхээс татгалзах эрхтэй.
- 3.1.4 Байгууллага цалин дамжуулах үйлчилгээг ашиглан хууль, энэ гэрээг зөрчсөн тохиолдолд нэг талын санаачлагаар гэрээг цуцлах, учирсан хохирлыг төлүүлэх;

3.1.5 Банкны системийн доголдол, техникийн саатлаас үүдэн байгууллагын дансанд давхар болон илүү мөнгөн дүнгээр гүйлгээ хийгдсэн тохиолдолд тус мөнгөн хөрөнгийг аливаа данснаас үл маргах журмаар суутгах, төлөхийг шаардах, битүүмж хийх эрхтэй.

3.1.6 Банк зээлийн шийдвэр гаргахдаа зээл хүсэгч ажилтны эрсдэлийн үнэлгээнээс хамааруулан зээлийн хүүгийн хэмжээг нэмэгдүүлэн шийдвэрлэх эрхтэй.

3.2 Банкны үүрэг

3.2.1 Гэрээний дагуу ажилтнуудад цалин дамжуулах үйлчилгээг ашиглах холбоос, нууц үгийг Банканд бүртгэлтэй и-мэйл хаягаар хүргүүлэх үүрэгтэй.

3.2.2 Тухайн үед хүчин төгөлдөр мөрдөгдөж буй шимтгэл, хураамжийн ерөнхий нөхцлийг өөрийн цахим хуудсанд байршуулах үүрэгтэй.

3.2.3 Харилцагчийн данс болон түүнтэй холбоотой мэдээллийг хуульд зааснаас бусад тохиолдолд бусад задруулахгүй байх үүрэгтэй.

3.2.4 Цалин дамжуулах үйлчилгээний талаар ирсэн харилцагчийн гомдол, хүсэлтийг Харилцагчийн мэдээллийн төвийн 1800-1917 утсаар эсвэл Банкны салбараар хүлээн авч, хүсэлтийг хүлээн авсан өдрөөс хойш хуанлийн 90 хүртэл хоногт багтаан шийдвэрлэнэ. Энэ хугацаанд шийдвэрлэх боломжгүй асуудлаар гарсан гомдол, хүсэлтийг холбогдох бүртгэлд бүртгэж, шийдвэрлэлтэд хяналт тавих бөгөөд энэ талаар харилцагчид мэдэгдэх үүрэгтэй.

3.3 Байгууллагын эрх

3.3.1 Цалин дамжуулах үйлчилгээний талаар гомдол, хүсэлтийг Харилцагчийн мэдээллийн төвийн 1800-1917 утсаар эсвэл Банкны салбарт хандан шийдвэрлүүлэх эрхтэй.

3.3.2 Үйлчилгээний эрхээ хаалгах, дахин бүртгүүлэх, үйлчилгээ ашиглах ажилтны нэвтрэх нэрийг солиулах, үйлчилгээг ашиглах ажилтныг нэмэх, хасах хүсэлтээ салбар, нэгжид бичлэн ирж гаргах эрхтэй.

3.3.3 Гэрээ цуцлах, дуусгавар болгох саналаа банкны салбар, нэгжид бичлэн ирж хүсэлт гаргах эрхтэй.

3.3.4 Цахим сувгаар хийсэн гүйлгээний баримтыг банкаар баталгаажуулах эрхтэй.

3.3.5 Гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлэхийг банкнаас шаардах эрхтэй.

3.4 Байгууллагын үүрэг

3.4.1 Гүйлгээг хийх болон хураамж суутгахад хүрэлцэхүйц дансны үлдэгдэлтэй байх, үлдэгдэл хүрэлцээгүй, системийн доголдол, техникийн саатлын улмаас хураамж татагдаагүй, эдгээртэй адилтгах бусад тохиолдолд данснаас үл маргах журмаар суутгуулах үүрэгтэй.

3.4.2 Гүйлгээ хийхтэй холбоотой шат дараалсан хяналтыг хариуцах үүрэгтэй.

3.4.3 Банкнаас баталсан гүйлгээний загварын дагуу гүйлгээний мэдээллийг бөглөх үүрэгтэй.

3.4.4 Банкны системийн доголдол, техникийн саатлын улмаас цалингийн гүйлгээ хийгдээгүй тохиолдолд Банкнаас өгөх заавар зөвлөмжийн дагуу хамтран ажиллах үүрэгтэй.

3.4.5 Энэхүү гэрээний нөхцөл, банканд бүртгэлтэй утасны дугаар, цахим шуудангийн хаяг, баталгаажуулах код болон холбогдох бусад мэдээлэл, баримтыг бусад задруулахгүй байх, задруулах, ашиглуулах нөхцөлийг бүрдүүлэхгүй, урьдчилан сэргийлэх үүрэгтэй.

3.4.6 Энэхүү гэрээний дагуу олж мэдсэн харилцагчийн дансны дугаар, мөнгөн шилжүүлгийн огноо, дүн болон бусад нууцлалтай мэдээллийг бусад задруулахгүй, задруулах, ашиглуулах нөхцөлийг бүрдүүлэхгүй байх үүрэгтэй.

3.4.7 Байгууллага нь данс болон үйлчилгээний эрхээ бусад ашиглуулахгүй байх, өөрийн дансаар бусад этгээдийн гүйлгээг дамжуулахгүй байх үүрэгтэй.

3.4.8 Цалин дамжуулах үйлчилгээгээр хийх гүйлгээний мэдээлэл болох хүлээн авагчийн нэр, дансны дугаар, мөнгөн дүн, гүйлгээний утга зэргийг нягталж үнэн зөв оруулах, үйлчилгээг ашиглан хийсэн гүйлгээний үнэн зөв байдлыг хариуцах;

3.4.9 Нэвтрэх болон гүйлгээний нууц үгийг бусад дамжуулсан, задруулсан, алдсан тохиолдолд нэн яаралтай Банкны лавлах 1800-1917 дугаарын утсаар, эсвэл Банкны салбарт биечлэн ирж мэдэгдэн, үйлчилгээний эрхээ түр хаалгах, бичгээр өргөдөл гаргах үүрэгтэй.

3.4.10 Банк болон бусад этгээдийн зүгээс харилцагчийн нэвтрэх нэр, нууц үг зэрэг мэдээллийг аливаа цахим болон веб хаягнаас хандаж, шаардсан тохиолдолд мэдээллээ өгөхгүй байх, ийм хүсэлт танд ирсэн тохиолдолд Банканд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.

3.4.11 Аливаа цахим үйлчилгээг ашиглаж дууссан даруйд програмаас бүрэн гарч байх үүрэгтэй.

3.4.12 Үйлчилгээг ашиглан гуравдагч этгээдэд төлбөр тооцооны үйлчилгээ үзүүлэхгүй, зуучлахгүй, хууль зөрчсөн бусад үйл ажиллагаа явуулахгүй байх үүрэгтэй.

3.4.13 Гэрээний 4.1-т заасан нөхцөл байдлын улмаас өөрт болон бусад учирсан хохирлыг бүрэн хариуцах үүрэгтэй.

3.4.14 Банкны зээлд хамрагдсан ажилтнуудын цалингийн өсөлт бууралтын талаар ажлын 3 хоногийн дотор банкинд мэдээлэх;

- 3.4.15 Банкны зээлд хамрагдсан ажилтантай байгуулсан гэрээ дуусгавар болсон цуцлагдсан тохиолдолд банкинд энэ талаар ажлын 1 хоногийн дотор мэдэгдэж тушаалын хуулбарыг хүргүүлэх, ажлаас гарах ажилтны тойрох хуудасны загварт банкнаас авсан зээлийн асуудлыг шийдвэрлэсэн талаар заалт оруулах;
- 3.4.16 Ажилтан банкнаас авсан зээлээ буцаан төлөхөөс зайлсхийсэн тохиолдолд үлдсэн төлбөрийг барагдуулахаар банктай хамтран ажиллах;
- 3.4.17 Гэрээ дуусгавар болсон ажилтанд тооцон олгох цалин, урамшуулал, нөхөн олговрыг ажилтны ХААН банк дахь дансанд шилжүүлэн олгох;
- 3.4.18 Банкнаас хүргүүлсэн мэдээ, мэдээллийг тухай бүр ажилтнууддаа танилцуулах;
- 3.4.19 Байгууллагын албан ёсны нэр хаяг, төлөөлөх эрх бүхий этгээд, тамга тэмдгийн дардаст өөрчлөлт орсон тохиолдолд тэр даруй банкинд мэдэгдэх;

ДӨРӨВ. ХАРИУЦЛАГА

- 4.1 Байгууллагын дараах буруутай үйлдэл, эс үйлдэхүйн улмаас харилцагчид учирсан хохирлыг Банк хариуцахгүй. Үүнд:
 - 4.1.1 Банкны системийн доголдол, техникийн саатлын улмаас цалингийн гүйлгээ хийгдээгүй, эсхүл хийгдэх боломжгүй байгааг Банканд утсаар болон биечлэн нэн даруй мэдэгдээгүйн улмаас учирсан хохирол;
 - 4.1.2 Байгууллага үйлчилгээний нууц үгийн хэвийн аюулгүй байдлыг хангаагүй, бусдад задруулсан, дамжуулж ашиглуулсан, Банканд бүртгүүлсэн мэдээллээ өөрчилсөн Банканд нэн даруй мэдэгдээгүйн улмаас учирсан хохирол;
 - 4.1.3 Гүйлгээний мөнгөн дүн, валютын төрөл, хүлээн авагчийн дансны дугаар, гүйлгээний утга зэрэг холбогдох мэдээллийг нягтлан шалгаагүй буруу оруулсны улмаас учирсан хохирол;
 - 4.1.4 Энэхүү гэрээний нөхцөлийг мөрдөөгүй, хүлээсэн үүргээ биелүүлээгүйн улмаас учирсан бусад хохирол;

ТАВ. ГЭРЭЭ ЦУЦЛАХ, ДУУСГАВАР БОЛОХ

- 5.1 Гэрээний хугацаа дуусгавар болж, талууд хүлээсэн үүргээ бүрэн биелүүлснээр гэрээ дуусгавар болсонд тооцно.
- 5.2 Байгууллага нь цалин дамжуулах үйлчилгээний эрхээ хаалгах, гэрээ цуцлах, дуусгавар болгох санал гаргах зэрэг тохиолдолд Банкны салбар, нэгжид биечлэн ирж хүсэлт гаргана. Банк хүсэлтийг хүлээн авч гэрээ цуцлах эсэхийг шийдвэрлэнэ.
- 5.3 Байгууллагын санаачлагаар гэрээг цуцлах бол Банканд ажлын 10-аас доошгүй өдрийн өмнө бичгээр мэдэгдэнэ. Хэрэв байгууллагын буруутай үйл ажиллагаанаас болж Банк гэрээг цуцлах бол мэдэгдэл өгснөөс хойш гэрээ цуцлагдсанд тооцно.
- 5.4 Банк дараах тохиолдлуудад өөрийн санаачлагаар гэрээг хугацаанаас нь өмнө цуцалж болох ба гэрээг цуцалснаас Банканд учирсан аливаа хохирол, түүнтэй холбогдон гарах зардлыг байгууллага бүрэн хариуцна.
 - 5.4.1 Байгууллага цалин дамжуулах үйлчилгээг ашиглан хууль, энэ гэрээг зөрсөн;
 - 5.4.2 Байгууллага гэрээний үүргээ хугацаанд нь зохих ёсоор биелүүлээгүй;
 - 5.4.3 Байгууллага худал мэдээлэл өгсөн, хуурамч бичиг баримтыг Банканд өгсөн;
 - 5.4.4 Хуульд заасан бусад үндэслэл

ЗУРГАА. БУСАД

- 6.1 Энэхүү гэрээг байгуулсан өдрөөс буюу талуудыг төлөөлөх эрх бүхий этгээдүүд гэрээнд гарын үсэг зурж, тамга дарж баталгаажуулснаар гэрээ хүчин төгөлдөр болох ба гэрээг монгол хэл дээр 2 хувь үйлдэж талууд нэг нэг хувийг хадгална. Талууд энэ гэрээний зүйл заалтуудыг нэн тэргүүнд баримтална. Энэ гэрээгээр зохицуулагдаагүй бусад асуудал Монгол Улсын холбогдох хууль тогтоомжоор зохицуулагдана.
- 6.2 Талууд гэрээтэй холбоотой маргааныг эв зүйгээр шийвэрлэхийг эрмэлзэх бөгөөд шийдвэрт хүрээгүй тохиолдолд маргааныг Монгол улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.
- 6.3 Талуудын санаачилгаар гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж болох ба ингэхдээ гэрээнд зааснаас бусад тохиолдолд гэрээг бичгээр байгуулж, гэрээний 6.1-т заасан журмын дагуу баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.
- 6.4 Энэхүү гэрээний дагуу олж мэдсэн аливаа мэдээ, мэдээллийг бусдад задруулахгүй байх үүргийг талууд хугацаагүйгээр хүлээнэ.

ГЭРЭЭГ ЗӨВШӨӨРЧ, БАЙГУУЛСАН:

БАНКИЙГ ТӨЛӨӨЛЖ
/Салбар, тооцооны төвийн захирал/
**ХААН
БАНК**
ХТ00938
(гарын үсэг)

(Г.Дамбасүрэн)

БАЙГУУЛЛАГА
/АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ, Захирал/
**АМГАЛАН
ДУЛААНЫ
СТАНЦ**
ТӨСК
(гарын үсэг) 6021646

(Ш.БАЯНМӨНХ)

| Зээлийн хэмжээ | Зээлийн хугацаа | Зээлийн хүү |
|---|---------------------|---------------------------|
| 24 сарын цалингийн хэмжээнээс хэтрэхгүй буюу 50,000,000.00 хүртэл төгрөг. | 1 - 12 хүртэлх сар | 14.4 % / сарын 1.20% / |
| | 13 - 18 хүртэлх сар | 15.6 % / сарын 1.30% / |
| | 19 - 24 хүртэлх сар | 15.6 % / сарын 1.30% / |
| | 25 - 30 хүртэлх сар | 16.8 % / сарын 1.40% / |

ГЭРЭЭГ ЗӨВШӨӨРЧ, БАЙГУУЛСАН:

БАНКИЙГ ТӨЛӨӨЛЖ
/Салбар, тооцооны төвийн захирал/
**ХААН
БАНК**
ХТ00938
(гарын үсэг)

(Г.Дамбасүрэн)

БАЙГУУЛЛАГА
УЛААНБААТАР ХОТ
/АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ, Захирал/
**АМГАЛАН
ДУЛААНЫ
СТАНЦ**
ТӨСК
9020030414 6021646
(гарын үсэг)

(Ш.БАЯНМӨНХ)